



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/140

Улаанбаатар хот

Тусгай зориулалтын автомашин
хүлээн авах ажлын хэсэг
байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны Эрх шилжүүлэх тухай А/467 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Ази, Номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн Япон сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах туршилтын төслийн хүрээнд хот нийтийн аж ахуйд шаардлагатай хог тээврийн тусгай зориулалтын 9 ширхэг автомашиныг нийлүүлэгч аж ахуйн нэгжээс тэрээнд заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу хянаж, актаар баталгаажуулан хүлээн авах Ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Хог тээврийн тусгай зориулалтын 9 ширхэг автомашиныг ашиглагч байгууллагуудад хүлээлцүүлэх, Нийслэлийн өмчид бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг (Б.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн удирдлагын газар (Н.Отгонбаяр)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Ц.ТӨРХҮҮ

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
...оны ...дугаар сарын ... өдрийн
... тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Мөнх-Эрдэнэ	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Ажлын хэсгийн гишүүд:	Л.Сүрэнхорлоо	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын Авто баазын менежер
	К.Жимсгуль	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын Авто баазын инженер
	Г.Эрдэнэ-Од	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын Авто баазын Засварын механик
	Д.Цэвээн-үр	Төслийн Худалдан авалт хариуцсан мэргэжилтэн
	Б.Батцэцэг	Төслийн Санхүүгийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Э.Хишигбуян	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн